



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/407

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн Засаг даргын 2023 оны А/356 дугаар захирамж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны ээлжит XX хуралдааны 07 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.8-д тусгагдсан "Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын, татвар төлөгчдийн болон бусад холбогдох бүртгэл мэдээллийг тодорхой болгох, татвар ногдох орлогыг үнэн зөв тогтоох ажлыг зохион байгуулж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх" заалтад тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх хүрээнд аялал жуулчлалын үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг ажиллахад шаардагдах зардалд 2,800.000 (Хоёр сая найман зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 2,800.000 (Хоёр сая найман зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны "Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардал"-аас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн), аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (Д.Балжинням) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ